

Оюутны бие даалт, ангийн ажилд баримтлах шаардлага

Боловсруулсан: *Е.Батчулуун*


Бакалавр, магистр, докторантын оюутнууд судалж буй хичээлээрээ бие даалт, ангийн ажил бичихэд дараах шаардлагыг баримтална.

1. Сэдвийн хувьд

- Оновчтой томъёологдсон, ерөнхий биш, тодорхой нарийн хүрээг хамарсан байна. Хэт ерөнхий бол гол асуудалд төвлөрч чаддаггүй. Жишээ нь: “Газарзүйн сургалтын аргазүй” - маш ерөнхий, докторын ажилд ч томдохоор байна. Үүнийг “Газарзүй-5 сурах бичгийн “Бүс нутгийн хөгжил” бүлэг сэдвийг заах арга зүй” гэвэл тодорхой болно.

2. Бичлэгийн хувьд

- Үг үсгийн алдаагүй байна.
- Нэг өгүүлбэрт байх үгийн тоог 25-аас хэтрүүлэхгүй.
- Гарчиг буюу агуулгыг эхний хуудсанд бичих ба хэрэв олон зураг, хүснэгт орсон бол тусад нь гарчиг байдлаар оруулна.
- Товчилсон үгс олон орсон бол жагсаалтыг тусад нь хийнэ. Олон давтагдах үгийн хувьд бол хамгийн эхнийхэд нь товчилсон хэлбэрийг нь хаалтан дотор бичээд цааш нь хэрэглэж болно.
- Газрын зураг, бүдүүвч, гэрэл зураг, диаграмм, график, схем зэргийг нийтэд нь “зураг” гэж үзэх ба “Зураг 1, Зураг 2” гэхчлэн дугаарлана.
- Зургийн нэрийг доод талд нь зүүн гар тал руу нь шахаж бичих ба авсан эх сурвалжийг хаалтад дурдана (Зураг 1).



Зураг 1. 1929-1989 оны хоорондох Нана-гийн усны нийт эзлэхүүн (куб м) (Эх сурвалж: *Vulman 2004*)

- Хүснэгтийн нэрийг дээд талд нь нь бичнэ.
- Текстийн холбогдох хэсэгт зураг ба хүснэгтийн дугаарыг хаалтан дотор бичнэ. Жишээ нь:(Зураг 3).....(Хүснэгт 5) гэх мэт.
- Цэг ба таслалыг үгийн ард (хооронд нь зай авахгүй) нь тавьж, дараа нь зай авна.

3. *Форматын хувьд*

- Font: Times new roman, үсгийн хэмжээ 11
- Цаас А4, зах бүрээсээ 2,5 см
- Шинэ мөр авахдаа enter дарах буюу нэг бүтэн мөр зай авна (Догол мөр авахгүй)
- Гарчиг, дэд гарчиг, бусад тодруулах үгсийг bold юмуу italic-аар ялгана. Гэхдээ нэг эрэмбэд хамаарах гарчиг ба дэд гарчиг зэргийн билэг, үсгийн хэмжээ зэрэг нь ижил байна.
- Хуудсыг дугаарлана. “Plain number 3”-ийг сонгох буюу баруун гар талын доод өнцөгт хуудасны дугаарыг тавина.

4. *Ишлэл авах*

- Бусад зүйлээс авсан мэдээлэл, ном, өгүүлэл зэргээс авсан хэсэг болгонд ишлэл буюу зүйлт заавал хийнэ.
- Текстэн дотор бол зохиогчийн нэр ба бүтээлийн хэвлэгдсэн оныг хаалтад бичнэ. (Miller 2007), (Ш.Шагдар 2005) гэх мэт.
- Олон зохиогчтой бол оны дарааллаар, нэг хүний нэг онд хэвлэгдсэн хэд хэдэн материалаас авсан бол үсгээр дугаарлана. Жишээ нь: (Zuckerman 1972; Barrett 1989; McNaughton, Reese, and Barrett 1989; Turner 1992, 1993; Parnell 1997a, 1997b)
- Шаардлагатай газар “footnote” хэрэглэж болно.

5. *Ашигласан материал буюу номзүйг бичих*

- Ажилдаа ашигласан эх сурвалж болгоныг ном зүйн жагсаалтад оруулна.
- Зохиогчийн нэрийг өмнө нь, овог юмуу овгийн эхний үсгийг ард нь тавина. Цэгмид. Ш, Barber, С гэх мэт.
- Зохиогчийн нэрийн цагаан толгойн үсгийн дэс дарааллаар жагсаана.
- Ном зүйг жагсаахдаа дугаарлахгүй, зураасан “Bullet” хэрэглэнэ.
- Нэг зохиогчийн, ижил он бүхий нэг онд гарсан материалаас авсан бол хэвлэгдсэн оных нь ард “а, б, в” гэх мэтээр дугаарлана (2013а, 2013б, 2013в гэх мэт). Жишээ нь:
 - Цэгмид. Ш (1969). *Монгол орны физик газарзүй*. УБ., Улсын хэвлэлийн газар. Хууд. 18-19
 - Шагдар. Ш (2005). *Монгол орны газарзүйн нэрийн тайлбар толь бичиг*. УБ., Мөнхийн үсэг. Хууд. 142.
 - Barber, С. 2010. A Moral Climate: The Ethics of Global Warming. *Cistercian Studies Quarterly* 45:221-223.
- Веб хуудаснаас авсан бол эхэнд нь зохиогч, эх сурвалж, газрын зураг болон бусад материалын нэрийг, дараа нь веб хуудсыг бичих ба уг мэдээллийн хамгийн сүүлд шинэчлэгдсэн хугацааг хаалтад бичнэ. Жишээ нь:
 - U.S. Department of Justice. 2008. About maps. <http://www.ojp.usdoj.gov/nij/maps/about.htm>. (last accessed 8 September 2008).

- Сониноос материал авсан бол нэр, он, дугаар болон түүнийг бичсэн хүний нэрийн хамт дараах байдлаар бичнэ. Жишээ нь:
 - Porcello, J.A. 2005. New Programs help attract firms. *Syracuse Herald American*, March 6.

Ашигласан материал

- MLA citation format (Modern Language Association). <http://www.calstatela.edu/library/guides/3mla.pdf>
- Annals citation format. <http://web.pdx.edu/~bulmant/generalcourseissues.php>
- Graphics in a Paper Dr. T. L. Bulman. Geography, Portland State University. <http://web.pdx.edu/~bulmant/generalcourseissues.php>

Жич анхаарах: Энэ талаар *Е.Батчулуун* “Газарзүйн боловсролын үндэс” номоос дэлгэрүүлэн үзэж болно. 2017 оны хэвлэл дээр 421-р хуудаснаас эхэлнэ. Ялагуяа 434-445-р хуудсанд Газарзүйн дидактикийн судалгаан дээр жишээлсэн хэсгийг үзээрэй. Мөн бодит жишээг 450-454-р хуудсанд үзүүлсэн байгаа. Эдгээр нь мөн номны 2020 оны хэвлэл дээр бол 425-аас эхлэнэ.